

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН НОРМТ ХУВЦАС, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ

**Төслийн нэр: “ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН НОРМТ ХУВЦАС, ЗӨӨЛӨН
ЭДЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ”**

Харьцуулалт/ гэрээний дугаар: ЦТЭ/202001002

**Улаанбаатар хот
2020 он**

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Цэргийн төв эмнэлэг] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **["НОРМТ ХУВЦАС, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ" харьцуулалтын аргаар худалдан авах] ЦТЭ/202001002 ГЭРЭЭГ ГҮЙЦЭТГЭХ** үнийн санал ирүүлэхийг урьж байна..

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 10 цаг 00 минут]**-аас өмнө www.tender.gov.mn сайтаар дамжуулан Цэргийн төв эмнэлэгт цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг **[2020 оны 09 дүгээр сарын 22]**-ны өдрийн **[10 цаг 10 минут]** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn цахим хуудаснаас татаж авна. Холбогдох бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Цэргийн төв эмнэлэг.
Лабораторийн нэгдсэн тасгийн эрхлэгч
Г. Янжмаа
Утас:99990547

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын танилцуулга; 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ; 3. 2019 оны ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагатай байх /Гэрээг хавсаргах/; 4. 2019 оны борлуулалтын орлого төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх; 5. 2019 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан; 6. Нийлүүлэх бүтээгдэхүүний чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан талаар улсын мэргэжлийн хяналтын байгууллага болон итгэмжлэгдсэн лабораторийн аль нэгнийх нь дүгнэлтийг хавсаргах; 7. Татварын өглөггүй байх, цахим татварын тодорхойлолт ирүүлэх; 8. Нийлүүлэх барааны үнийн санал, нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан ирүүлэх; 9. Нийлүүлэх бүтээгдэхүүний дээж ирүүлэх.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>[Цэргийн төв эмнэлэг. УБ хот, БЗД, Энх тайвны өргөн чөлөө -51]</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>[Цэргийн төв эмнэлэг. Урьдчилан сэргийлэх байр, 1 давхар, 116 тоот]</i></p> <p>Огноо: <i>[2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр]</i> Цаг: <i>[10 цаг 00 минут]</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>[Цэргийн төв эмнэлэг. УБ хот, БЗД, Энх тайвны өргөн чөлөө -51]</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>[Цэргийн төв эмнэлэг. Урьдчилан сэргийлэх байр, 1 давхар, 116 тоот]</i></p> <p>Огноо: <i>[2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр]</i> Цаг: <i>[10 цаг 10 минут]</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><i>Багц №1. Ороолт футболк, металл мөрдэс, суран бүс</i></p> <p><i>Багц №2. Малгай</i></p> <p><i>Багц №3. Савхин дээл, бээлий</i></p> <p><i>Багц №4. Эмнэлгийн ажилчдын хувцас хэрэглэл</i></p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


БАГЦ №1 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Хээрийн богино ханцуйтай цамц /футболка


Чанар, стандартын шаардлага	
	МУЕ-ийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварыг баримтлана. MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.
	Бор шаргал өнгөтэй. сүлжмэл даавуу материалтай
	Нийлүүлэгчийн шошго/хаяг/ размер хэмжээг хадсан байх ба ус чийгнээс хамгаалагдсан нэг бүрчлэн савласан байна.
	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.	
Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.

БАГЦ №1 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: хүзүүний ороолт /саарал/


Чанар, стандартын шаардлага	
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварын шаардлага хангасан байх. MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.	
	үндсэн материал нь саарал өнгийн хагас ноосон утсаар нэхэгдсэн будаг гардаггүй, хүний биед харшил өгөх нөлөөгүй байна.
	Хэмжээ 120x20 см
	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
Тендерийн нээлтээс өмнө загвар бүтээгдэхүүний дээжийг ирүүлнэ.	

БАГЦ № 1 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
 Бүтээгдэхүүний нэр: хүзүүний ороолт /бор ногоон/


Чанар, стандартын шаардлага	
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 175 дүгээр зарлигаар батлагдсан загварын шаардлага хангасан байх. MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.	
	үндсэн материал нь бор ногоон өнгийн хагас ноосон утсаар нэхэгдсэн будаг гардаггүй, хүний биед харшил өгөх нөлөөгүй байна.
	Хэмжээ 120x20 см
	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.

БАГЦ №1 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
 Бүтээгдэхүүний нэр: Цолны тэмдэг


Чанар, стандартын шаардлага	
1	Цолны тэмдэг нь: а/ Ахлах офицерын таван хошуу-21 мм алтан шар болон мөнгөлөг саарал өнгөтэй б/ Дунд офицерын таван хошуу-14 мм алтан шар болон мөнгөлөг саарал өнгөтэй в/ Ахлагчийн гурвалжин дүрс хэлбэртэй алтан шар болон мөнгөлөг саарал өнгөтэй цолны тэмдэг байна. Тогтоогч нь бөх, бат сайн чанартай байна. Тогтоогч нь боолтоор чангалдаг маш сайн чанартай хийгдсэн байна.
2	МУЕ-ийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварыг баримтлана. MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.
3	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
4	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.



БАГЦ №1 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Бүтээгдэхүүний нэр: Энгэрийн таних тэмдэг


Чанар, стандартын шаардлага	
	Өнгө нь алтлаг шар өнгөө алдахгүй байна. Тогтоогч нь бат бөх суурьтай, хугарахгүй, хоёр тийш дэлгэгдэн тогтооно.
	МУЕ-ийн 1998 оны 180 дугаар зарлигаар батлагдсан загварыг баримтлана.
	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.

БАГЦ №1 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Бүтээгдэхүүний нэр: Офицер, ахлагч нарын суран бүс

Нэг: Үндсэн ба туслах материал	
МУЕ-ийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварыг баримтлана. MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.	
	Технологийн дагуу боловсруулсан зөөлөн 0.3 мм зузаан шир /бор хүрэн өнгийн/ шар өнгийн төмөр арал, доторлогооны материал хадаас зэрэг үндсэн туслах материал нь чанарын шаардлага хангасан байна. 2 дэгээтэй байна. Бүсний арал талаас 50 см доторлогоотой 1 кольцтой байна. Бүсний арлыг зориулалтын 3 хадаасаар хадаж тогтооно. Бүсний үзүүрээс 12 см-ийн зайд нүхний төгсгөл байрлана. Нүхний төгсгөлөөс 2.5 см-ийн зайтай 10 ширхэг 2 эгнээ нүхтэй байна. 2 хэлтэй, хэл хоорондын зай 2.0 см байна.
	Арал: 2 хэлтэй, гялгар шар төмрөөр хийгдсэн байна.
	Бүсний өргөн 5 см урт нь 115-160 см байна.
	Чанар: хүйтний улиралд хөлдөж хугарахгүй байна.
	Загварын хэв маяг, гадаад үзэмж материалын болон оёдлын чанар байдал, шаардлагад нийцсэн байна.
	Тендерийн нээлтээс өмнө 1 ш загварыг, зохих байгууллагын дүгнэлт гаргуулан ирүүлнэ.
Гэрээнд тусгагдах онцлог нөхцөл тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.

БАГЦ №2 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Цегейк малгай

Чанар, стандартын шаардлага	
	<p>Малгайн чих, цох, ар шилний өнгө нь ижил, үс өндөр, намгүй жигд байна. Цегейк үсний өндөр 1.5 см байна.</p> <p>Малгайн бүчийг 15 см урт, 0.8 см өргөнтэйгээр өнгө дагуу материалаар хийж, чихний ирмэгийн голд машинаар хадсан байна. /ОХУ-д үйлдвэрлэсэн загварын малгайн чанар шаардлагыг хангахуйц.</p>
	<p>МУЕ-ийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварыг баримтлана.</p> <p>MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.</p>
	<p>Малгайн оройн залгаас өөр хоорондоо ижил, хойд урд талыг голлосон байна. Малгайн цох, чихний үсэнд зүйдэл оруулахыг зөвшөөрөхгүй. Цегейк үсний ширхэг дээшээ, налсан шигүү байна. Малгайн өнгөний ирмэг үсний ирмэгээс давсан байж болохгүй. Малгайн чих, цох, ар шилийг зузаан ширмэл зулхайг давхарлан доторлосон байна. Өнгө нь хөх саарал байна.</p>
	<p>Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.</p>
	<p>Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.</p>
	<p>Тендерийн нээлтээс өмнө загвар бүтээгдэхүүний дээжийг ирүүлнэ.</p>
Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	<p>1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсөн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.</p>


БАГЦ №3 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Цегейк захтай, салдаг дотортой савхин дээл /хатгамал мөрдөстэй/

Нэг: Стандарт техникийн шаардлага	
<p>МУЕ-ийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварыг баримтлана.</p> <p>MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.</p>	
	<p>Технологийн дагуу боловсруулсан ямааны зөөлөн бор савхи, будгийн тогтвор хэвийн, арьсны зузаан 0.8-1.2, суналт хэвийн байна.</p> <p>Цегейк арьс нь өнгө жигд хөх, хөрс уян зөөлөн, тослоггүй бөх бат, үсний өндөр нам жигд байна.</p>
Туслах материал	
1	Нимгэн дотор, наалт, цавуу
2	Ширмэл дотор, зулхай, цегейк, мөр, урт, богино цахилгаан
3	Нэхмэл манжет, том, дунд, контор товч, кноп, шнур, зангуу, оёдлын утас гэх мэт үндсэн туслах материалууд нь механик үйлчлэлд өнгө хувирахгүй будаг гардаггүй гандахгүй, чанартай материалаар батлагдсан өнгө загвараар үйлдвэрлэгдсэн байна.

Хоёр: Техникийн нөхцөл	
1	Савхин дээл нь батлагдсан стандартын дагуу газраас 36 см зайтай байна.
2	Синтофонтой салдаг дотортой, ханцуй нь сүлжмэл манжеттай, дотор нь цахилгаантай байна.
3	Офицер, ахлагч нарт цегейк захтай хийнэ.
4	Өвлийн цегейк зах нь ар захандаа кнопоор, дотор захандаа товчоор товчлогдоно.
5	Өнгө дагуу савхиар хатуулгатай 9x5 хэмжээтэй угладаг цолны хатгамал мөрдөстэй байна.
Гурав: Оёдлын тайлбар	
1	Бүх гоёлын оёо 02-08 см, түүний нугалах ирмэгүүд 1.5 см байна. Хатгаш 1 см – т 2 - 2.5 байна.
2	Хагалж наах ба дотрын 1-р оёо 1 см байна. Дотрын ба хавсарч оёсон оёдлыг 1 см-т 4-5 хатгаштайгаар оёно.
3	Ар энгэрийн кокетка, нудрага, ар холбоосны эмжээр (хавчаар) 0.2 см байна.
	Зүүн суганд тухайн хүний анги, нэр, размер, кодыг бичсэн санамж хавчуулж оёно.
Дөрөв: Чанарын шаардлага	
1	Савхин хувцасыг батлагдсан загвар, технологийн заавар болон техникийн холбогдох бичиг баримтын дагуу үйлдвэрлэнэ.
2	Савхин хувцасны чанар нь: хэрэглээний болон физик механикийн үзүүлэлт гадаад үзэмжээр тодорхойлогдоно. а) Өнгөний зохицол, хэрэглээний ба гоёлын чимэглэл тоноглол нь тухайн загварын хэв маягт нийцсэн байна. б) Хүний биед тохирч буй байдал в) Материалын чанар
3	Цэргийн савхин дүрэмт хувцас нь: Зохион бүтээлтийн хувьд орчин үеийн шаардлага хэрэгцээнд нийцсэн, өнгө, материалын зохицол сайтай биенд хөнгөн бөгөөд тохиромжтой чөлөөт хөдөлгөөнд саад болохооргүй хийгдсэн байна.
4	Оёоны жигд байдлыг 1 см уртад оёсон хатгацын тоогоор тодорхойлно.
5	Хувцсыг хүлээж авахдаа: Батлагдсан загвар, түүнийг үйлдвэрлэхэд мөрдөх стандарт бусад норматив техникийн бичиг баримтын дагуу нэг бүрчлэн шалгана.
6	Хувцасыг уутанд хийж анги хэсгийн нэрийг бичсэн зориулалтын өлгүүрт өлгөж хадгална.
7	Тендерийн нээлтээс өмнө загвар бүтээгдэхүүний дээжийг ирүүлнэ.
Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Үйлдвэрлэл эхлэхийн өмнө үндсэн ба туслах материал размер бүрийн эсгүүрийн үлгэрийг захиалагч талын мэргэжилтэнд үзүүлж, бичгээр зөвшөөрөл авна. 2. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй. 3. Үндсэн ба туслах материал нь захиалагч талаас гаргасан бүтэц, чанар, өнгө хэмжээтэй нийцсэн байна.

БАГЦ №3 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Бүтээгдэхүүний нэр: Савхин бээлий

Нэг: Дээд эд ангийн тодорхойлолт	
МУЕ-ийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварыг баримтлана. MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.	
1	Хар өнгөтэй ямааны арьсаар хийгдсэн байна.
2	Дотор: хөвөн даавуу сүлжмэл материал
Хоёр: Загварын эд ангийн техникийн тодорхойлолт	
	Чийг шингээх гадагшлуулах чадвар өндөр нягт, нугаралтанд уян хатан
	Утас: савхины зориулалтын бөх бат
	Бүтээгдэхүүнд өнгө үзэмж чанар сайжруулах нэмэлт ажиллагаа хийгдсэн байна.
	Загварын хэв маяг, гадаад үзэмж, оёдлын чанар байдал, материалын чанар нь УСТ-ын нөхцөл хангасан байна.
	Тендерийн нээлтээс өмнө загвар бүтээгдэхүүний дээжийг ирүүлнэ.
Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Үйлдвэрлэл эхлэхийн өмнө үндсэн ба туслах материал размер бүрийн эсгүүрийн үлгэрийг захиалагч талын мэргэжилтэнд үзүүлж, бичгээр зөвшөөрөл авна. 2. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй. 3. Тендерийн материалын хамт загвар ирүүлнэ.

БАГЦ №4 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Бүтээгдэхүүний нэр: Эмнэлгийн ажилчдын хувцас, хэрэглэл

Бүтээгдэхүүний нэр	Техникийн шаардлага
Эмч халад, малгай	<p>Материал: Халадны зориулалтын материалаар хийгдсэн байна. Даавууны хольц 70 хувь хөвөн даавуу, 30 хувь полистер холиотой байна. Сайн чанарын биед эвтэйхэн, 130 градуст индүүдлэг авдаг, агшдаггүй 60-80 градуст угаах, хатаах нөхцөлд сунахгүй, агшихгүй, материалаар хийгдсэн байх.</p> <p>Загвар, хэмжээ: Эмнэлгийн зориулалтын халад байна. Цагаан өнгөтэй, урт ханцуйтай, бариу биш, энгийн хийцтэй, урт нь өвдөгнөөс доош хоёр хуруу, зах бартаа нь эгэмнээс доошгүй цэвэрхэн байх, гэрэлтдэггүй материалтай, индүүдлэг авдаг байна. Утас, товч, ярлык, дэгээ, гогцоо зэрэг туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Үндсэн материалд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгөтэй байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2). Бүх хувцас хэрэглээний чимэг оёдлыг 1см-т 5-6 дотрын ба хавсарч оёсон оёдлыг 1см-т 4-5 хатгаштайгаар оёно. Хамгаалалтын сав баглаа боодолтой байна.</p> <p>Зүүн энгэр хэсэгт халаастай цэнхэр эмжээртэй, 2 хажуу хормойд халаастай, эмнэлгийн логотой, логоны диаметр 7 см, ширмэл байна. Европ стандартын хэмжээний сонголттой.</p> <p>Малгай: Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдөж буй</p>

	<p>чанарын шаардлага хангасан. Үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан байна. Үйлдвэрийн гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгийн бат бөх чанартай байна. Хамгаалалтын сав баглаа боодолтой байна.</p>
--	---

<p>Сувилагч халад, малгай</p>	<p>Материал: Халадны зориулалтын материалаар хийгдсэн байна. Даавууны хольц 70 хувь хөвөн даавуу, 30 хувь полистер холиотой байна. Сайн чанарын биед эвтэйхэн, 130 градуст индүүдлэг авдаг, агшдаггүй 60-80 градуст угаах, хатаах нөхцөлд сунахгүй, агшихгүй, материалаар хийгдсэн байх.</p> <p>Загвар: ТББ-д зургаар харуулсан болно. Ханцуй: шулуун урт, халад ардаа тохируулж товчилдог бүстэй.</p> <p>Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдөж буй чанарын шаардлага хангасан. Үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан байна. Үйлдвэрийн гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгийн бат бөх чанартай байна. Хамгаалалтын сав баглаа боодолтой байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2). Бүх хувцас хэрэглээний чимэг оёдлыг 1см-т 5-6 дотрын ба хавсарч оёсон оёдлыг 1см-т 4-5 хатгаштайгаар оёно.</p> <p>Зүүн энгэр хэсэгт халаастай, 2 хажуу хормойд халаастай, эмнэлгийн логотой, логоны диаметр 7 см, ширмэл байна. Эмч халадаас ялгагдах цэнхэр захтай байх. Европ стандартын хэмжээний сонголттой.</p> <p>Малгай:</p> <p>Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдөж буй чанарын шаардлага хангасан. Үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан байна. Үйлдвэрийн гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгийн бат бөх чанартай байна. Хамгаалалтын сав баглаа боодолтой байна.</p>
-----------------------------------	--

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Багцын дугаар	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	3	4	5	6	7	8	9
[Дугаар бичих]	[Барааны товч тодорхойлолтыг бичих]	[Нэгжийн тоо ширхэгийг бичих]	[хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрыг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
1	Хүзүүний сарал ороолт	100	ш	Цэргийн төв эмнэлэг	Гэрээ байгуулсан хугацаа	2020.12.25	
	Хүзүүний ороолт /бор ногоон/	100	ш				
	Хээрийн богино ханцуйтай цамц /захгүй/	125	ш				
	Мөнгөлөг саарал жижиг таван хошуу	50	ш				
	Мөнгөлөг саарал гурвалжин дүрс бүхий тэмдэг	40	ш				
	Энгэрийн таних тэмдэг	30	хос				
	Алтан шар жижиг таван хошуу	48	ш				
	Алтан шар гурвалжин дүрс бүхий тэмдэг	40	ш				
	Малгайн тэмдэг	20	ш				
	Малгайн сагалдарга	20	ш				

	Суран бүс	20	ш				
2	Өвлийн малгай /цегейк/	30	ш	Цэргийн төв эмнэлэг	Гэрээ байгуулсан хугацаа	2020.12.25	
3	Цегейк захтай, савхин гадартай, салдаг дотортой дээл/хатгамал мөрдөстэй/	20	ш	Цэргийн төв эмнэлэг	Гэрээ байгуулсан хугацаа	2020.12.25	
	Савхин бээлий	20	хос				
4	Эмчийн халад, малгай	50	хос	Цэргийн төв эмнэлэг	Гэрээ байгуулсан хугацаа	2020.12.25	
	Сувилагчийн халад, малгай	50	хос				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Цэргийн төв эмнэлгийн)-ын дарга Хурандаа С.Батболд танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[моо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

- 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[моо]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[моо]**
- Алдангийн нийт дүн: **[моо]**

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]